



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар

08А-2022/30-13-ШТА-ГА/А.158.0.347/253

Арвайхээр

БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГА М.МӨНХБАЯР ТАНАА  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан ӨВА-2022/30-13-ШТА-ГА кодтой төлөвлөгөөний дагуу "Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн" -д аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.2-т "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн төсөв санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мөнгөн болон бусад гүйлгээг хамруулахаар заасны дагуу ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт 19-д тусгасан маягтын дагуу цахим хуудсанд 4 аж ахуйн нэгж 104.5 сая төгрөгийн зарлагыг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-т "Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй" -гэж заасныг биелүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр олгосон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт 19-д тусгасан маягтаар цахим хуудсанд байршуулж гэрээний биелэлтийг хангуулж ажиллах.

2. Дээрх зөрчлийг арилгаж биелэлтийг 2022 оны 11 дугаар сарын 20-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн Аудитын газарт албан тоотоор ирүүлэхийг Бүрд сумын Засаг дарга М.Мөнхбаяр, Санхүүгийн албаны дарга Г.Анхтөр нарт хариуцуулав.<sup>25</sup>

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АХЛАХ АУДИТОР

Б.ХОРЛООСҮРЭН

АУДИТОР

Ө.РИНЧИНМЯДАГ

АУДИТОР

Э.ЭНХБАЯР

<sup>25</sup> Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42.1 Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүрэгээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар шлэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар ЭМ - 2022/30-13-ШТА-ГА/А/1560347/233 Арвайхээр

БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГА М.МӨНХБАЯР ТАНАА  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан ЭВА-2022/30-13-ШТА-ГА кодтой төлөвлөгөөний дагуу "Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн" -д аудит хийхэд Бүрд суманд иргэдийн санал аваагүй спорт заал, залуучуудын хөгжлийн төвийн дулааны шугамын засвар 20.0 сая төгрөг, хүүхдийн тоглоомын талбай 20.0 сая төгрөг, сургуулийн биеийн тамирын зааланд бөхийн дэвжээ 3.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээг баталж санхүүжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4-т "Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа"; 60.3.6-т "Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ"; Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 6.3.5 "Иргэдийн оролцоог хангасан байх" Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн сангийн үйл ажиллагааны журам" -ын 3 дугаар зүйлийн 3.1.2.-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх; гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг мөрдөн ажиллаж, орон нутгийн иргэдийн санал аваагүй ажлыг ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлэхгүй байх.
2. Дээрх зөрчлийг арилгаж биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн Аудитын газарт албан тоотоор ирүүлэхийг Бүрд сумын Засаг дарга М.Мөнхбаяр, Санхүүгийн албаны дарга Г.Анхтөр нарт хариуцуулав.<sup>3</sup>

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН:  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **О. БАТЖАРГАЛ**  
АХЛАХ АУДИТОР **Н. ХОРЛООСҮРЭН**  
АУДИТОР **Ө. РИНЧИНМЯДАГ**  
АУДИТОР **Э. ЭНХБАЯР**

<sup>3</sup> Акт албан шаардлагын биелэлт хангаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42.1 Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хуацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүнгэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчийн сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар ӨВА-2022/30-13-ШТА-ГА/А/350397620  
Арвайхээр

БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГА М.МӨНХБАЯР ТАНАА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан ӨВА-2022/30-13-ШТА-ГА кодтой төлөвлөгөөний дагуу "Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн" -д аудит хийхэд Бүрд сум малын тоо толгойн албан татварын 35.7 сая төгрөгийг хуулийн хугацаанд нь төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Малын тоо толгойн албан татварын 2021 онд дутуу төвлөрүүлсэн 35.7 сая төгрөгийг сумын ОНХС-гийн дансанд төвлөрүүлэх.

2.Актын биелэлтийг биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн Аудитын газарт албан тоотоор ирүүлэхийг Бүрд сумын Засаг дарга М.Мөнхбаяр, Санхүүгийн албаны дарга Г.Анхтөр нарт хариуцуулав. <sup>7</sup>

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *О.Батжаргал* О.БАТЖАРГАЛ  
АХЛАХ АУДИТОР *П.Хорлоосүрэн* П.ХОРЛООСҮРЭН  
АУДИТОР *Ө.Ринчинмядаг* Ө.РИНЧИНМЯДАГ  
*Э.Энхбаяр* Э.ЭНХБАЯР

<sup>7</sup> Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

*Г. Анхтөр*  
*М. Мөнхбаяр*  
*2022.06.03*